

этгээдийг баривчлах тухай тогтоол гарсан буюу шуухийн тогтоол хучин төгөлдөр болсныг иш татаж шилжуулэн өгөх тухай шаардлага явуулснаа мэдэгдвэл Хэлэлцэы Тохирогч нөгөө этгээдийн зохих байгууллага шилжуулэн өгөх тухай шаардлагыг хүлээн авахаас өмнө уг этгээдийг баривчилж болно. Ийм хусэлтийг шуудан цахилгаан буюу утсан харилцаа зэргээр мэдэгдэнэ.

2. Хэлэлцэн Тохирогч наг Этгээдийн засаг төрийн эрх бүхий байгууллага нутаг дэвсгэртээ байгаа этгээдийн талаар энэ зуйлийн I дэх ангид заасан хусэлтийг хүлээн аваагуй боловч хэрэв уг иргэн Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг уйлдсэн тухай илэрсэн мэдээг ундэслэн энэхуу Гэрээний 74-р зуйлд зааснаар туунийг баривчилж болно.

3. Энэ зуйлийн I, 2 дахь ангид зааснаар баривчилсан тухайгаа Хэлэлиэн Тохирогч нөгөө Этгээдэд нэн даруй мэдэгдэнэ.

Наян гуравдугаар зуйл

1. Хэрэв Гэрээний 80 дугаар зуйлд заасан хугацаанд шилжуулэн өгөхшаардлагын талаар нэмэлт материал хүлээн аваагуй бол шилжуулэн өгөх тухай шаардлагыг хүлээн авч байгаа Хэлэлиэн Тохирогч Этгээд шилжуулэн өгөх ажиллагааг зогсоож иагдан хорьж байгаа иргэнийг суллана.

2. Баривчилсан тухай мэдэгдсэн өдрөөс хойш хэрэв хоёр сарын дотор Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээд шилжуулэн өгөх тухай шааидлага явуулаагуй бол Гэрээний 82 дугаар зуйлийн дагуу цагдан хорьсон этгээдийг суллаж болно.

Наян дөрөвдүгээр зуйл

Иилжуулэн өгөхийг хойшлүүлэх

I. Хэрэв шилжуулэн өгвөл зохих этгээд шилжуулэн өгөх тухай шаардлагыг хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн нутаг дэвогэрт уйлдсэн өөр гэмт хэргийн учир эруугийн